

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/8¹ дүгээр зүйл:

8¹ дүгээр зүйл. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, дахин боловсруулах, устгах журам

8^{1.1}. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дараахь үүрэг хүлээнэ:

8^{1.1.1}. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнээс татан авах дотоод журам, хариуцсан ажилтантай байх;

8^{1.1.2}. хяналтын байгууллагын шийдвэрийг үндэслэн өөрт хамаарах хүнсний сүлжээний дараагийн үе шатанд нийлүүлсэн, борлуулсан болон үлдэгдэл тоо хэмжээний талаарх судалгааг гаргаж, шаардлага хангаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг 48 цагт багтаан татан авах үйл ажиллагааг зохион байгуулж, энэ талаар бүртгэл хөтлөх;

8^{1.1.3}. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авч дуусмагц энэ талаар хяналтын байгууллага, хэрэглэгч болон тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авсан хүнсний сүлжээний дараагийн шатны үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэж, сэрэмжлүүлэг хүргүүлэх.

8^{1.2}. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авахтай холбогдуулан хяналтын байгууллага дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

8^{1.2.1}. хэрэглэгч, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчээс ирүүлсэн мэдээллийг хянан үзэж, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах тухай албан ёсны шийдвэрийг мэдээлэл авснаас хойш 12 цагийн дотор багтаан гаргаж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид хүргүүлэх;

8^{1.2.2}. энэ хуулийн 8.2-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах тухай албан ёсны шийдвэрийг 2 цагийн дотор багтаан гаргах;

8^{1.2.3}. татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах, дахин боловсруулах тухай шийдвэрийг татан авалтын үйл ажиллагаа дууссанаас хойш ажлын 14 хоногийн дотор гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

8¹.2.4. татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах, эсхүл дахин боловсруулах талаар акт үйлдэх;

8¹.3. Татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь мал, амьтан, ургамалд аюултай үр дагавар үүсгэхгүй нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгээр баталгаажсан тохиолдолд шинж чанар, зориулалтыг өөрчлөн, мал, амьтны тэжээл, ургамлын бордооны зориулалтаар дахин боловсруулж хэрэглэж болно.

8¹.4. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дахин боловсруулах үйлдвэрлэлийн явцад улсын байцаагч хяналт тавина.

8¹.5. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг дахин боловсруулж гаргасан мал, амьтны тэжээл, ургамлын бордоог лабораторийн шинжилгээний дүгнэлтэд үндэслэн зориулалтын дагуу хэрэглэнэ.

8¹.6. Татан авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүний амь нас, эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон, эсхүл гарал үүсэл нь тодорхойгүй, эсхүл дахин боловсруулж ашиглах боломжгүй тохиолдолд улсын байцаагч лабораторийн сорил, дүгнэлтэд үндэслэн устгах акт гаргана.

8¹.7. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах ажлыг улсын байцаагч, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулан зориулалтын шаардлага хангасан газарт зохион байгуулан устгах ба оролцогч талууд хамтарсан акт үйлдэнэ.

8¹.8. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 15.1-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгах асуудлыг тухайн хилийн боомт, гүний гааль байрлаж буй сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг улсын байцаагчийн хяналтын дор гүйцэтгэж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг устгасан тухай акт үйлдэн зөрчлийн хэрэгт хавсаргана.

8¹.9. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шаардлага хангаагүй талаарх мэдээллийн эсрэг холбогдох этгээдэд гомдол гаргах эрхтэй.

8¹.10. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах талаарх хяналтын байгууллага, улсын байцаагчийн акт, шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо төрийн захиргааны зохих шатны байгууллага, албан тушаалтанд гаргаж болно.

8¹.11. Хүнсний сүлжээнээс хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, дахин боловсруулах, устгах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал, лабораторийн шинжилгээний төлбөр, бусдад учруулсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

2/17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт:

“17.1.4. энэ хуулийн 12.5.3-т заасан тэмдгийн загвар, хэрэглэх зааврыг батлах.”

2 дугаар зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5.3 дахь заалтын “хүнсний нэмэлт” гэсний өмнө “баяжуулсан хүнс,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “маягтын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр” гэснийг “цахимаар” гэж, 8 дугаар зүйлийн 8.6, 8.7 дахь хэсгийн “8.10-т” гэснийг “8¹ дүгээр зүйлд” гэж, мөн зүйлийн 8.10 дахь хэсгийн “журмыг Засгийн газар батална.” гэснийг “боловсруулахтай холбоотой харилцааг энэ хуулийн 8¹ дүгээр зүйлд заасан журмаар зохицуулна.” гэж, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “тогтоох” гэснийг “боловсруулж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх” гэж, мөн зүйлийн 17.1.3 дахь заалтын “тогтоох” гэснийг “тогтоосон стандартын төслийг боловсруулж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “12.3,” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 9 дүгээр зүйлийн 9.6, 12 дугаар зүйлийн 12.2, 12.3, 13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/6¹ дүгээр зүйл:

“6¹ дүгээр зүйл. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам

6¹.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ онцлог, цаг агаар, уур амьсгал болон үйлдвэр, хадгалах агуулахын багтаамж, хүн амын тоо, өсөлт, бууралтыг харгалзан хэрэгцээ, эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан энэ хуулийн 3.1.6-д заасан хүнсний нөөцийг бүрдүүлэх ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

6¹.1.1. харьяалах нутаг дэвсгэртээ бүрдүүлэх болон бусад аймаг, нийслэлээс авах нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг тогтоох;

6¹.1.2. бусад аймаг, нийслэлд нийлүүлэх боломжтой нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг тогтоох;

6¹.1.3. дараа жилийн бэлтгэх нөөцийн нэр төрөл, тоо хэмжээний саналыг өмнөх жилийн нөөцийн зарцуулалтын тайлангийн хамт хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх.

6¹.2. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлээс ирүүлсэн саналыг нэгтгэж, улсын хэмжээнд бүрдүүлэх нөөцийн мэдээллийг гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд Засгийн газарт танилцуулж нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг тогтоож болно.

6¹.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь тогтоосон тоо хэмжээний нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг орон нутгийн тухайн жилийн төсөвт тусгуулна.

6¹.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сонгон шалгаруулалтын үндсэн дээр бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулан орон нутгаас нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

6¹.5. Энэ хуулийн 6¹.4-т заасан нөөц бүрдүүлэх үйл ажиллагаанд зээлийн хүүгийн хөнгөлөлт, татаас, эсхүл энэ хуулийн 8.5-д заасны дагуу урамшуулал өгөх хэлбэрээр дэмжлэг үзүүлж болно.

6¹.6. Энэ хуулийн 6¹.4-т заасан гэрээнд нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, чанар, аюулгүй байдлын үзүүлэлт, бэлтгэх болон худалдах хугацаа, борлуулалтын

төлөвлөгөө, хуваарь, эрсдэлээс шалтгаалан гэрээний заалт үл биелэгдэх нөхцөл үүсэх, түүнээс гарах үр дагавар, хариуцлагын талаар тусгана.

6¹.7. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь бэлтгэсэн нөөцийн мэдээллийг доор дурдсан хугацаанд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

6¹.7.1. мах, ундны усны нөөцийн мэдээллийг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

6¹.7.2. сүүний нөөцийн мэдээллийг тухайн жилийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

6¹.7.3. улаанбуудай, тарианы үр, гурилын нөөцийг тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

6¹.8. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 6¹.7-д заасан мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллага, иргэдийг мэдээллээр хангана.

6¹.9. Бэлтгэн нийлүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

6¹.9.1. энэ хуулийн 10.1, 10.3, Эрүүл ахуйн тухай хуулийн 7.1, 7.3, 7.4, 7.5-д заасан шаардлагыг хангасан байх;

6¹.9.2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1, 10.3-т заасан үүргийг биелүүлэх.

6¹.10. Нөөц нь дараах шаардлагыг хангасан байна:

6¹.10.1. Эрүүл ахуйн тухай хуулийн 8.1, 8.4, 8.5, 8.6-д заасан шаардлагыг хангах;

6¹.10.2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.1, 12.4-т заасан шаардлагад нийцсэн байх.

6¹.11. Бэлтгэсэн нөөцийг Монгол Улсын болон олон улсын стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн агуулахад хадгална.

6¹.12. Бэлтгэсэн нөөцийг бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр түүний агуулахад хадгалж болно.

6¹.13. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь бэлтгэсэн нөөцийг стандартын шаардлага хангасан байр бүхий тухайн орон нутгийн хүнсний чиглэлийн худалдаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан худалдах замаар зарцуулалтыг зохион байгуулна.

6¹.14. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь нөөц зарцуулах үйл ажиллагааны явцын мэдээг нөөц худалдаж эхэлснээс хойш сар бүр хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6¹.15.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нөөцийн мэдээлэлд үндэслэн боломжит нөөцийг бусад орон нутагт шилжүүлэх саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж болно.

6¹.16.Аймаг, нийслэл дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх байгууллага болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тэдгээрийн улсын байцаагч нь холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу тухайн бэлтгэсэн нөөцийн чанар, аюулгүй байдал, баталгаажилт, гарал үүсэл, хадгалалт, тээвэрлэлтэд хяналт тавина.

6¹.17.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь бэлтгэн нийлүүлэгч, хүнсний худалдаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.

6¹.18.Төрийн бус байгууллага нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт, үнэд хөндлөнгийн хяналт тавьж болно.

6¹.19.Аймаг, нийслэл дэх татварын байгууллага нь нөөцийг татварын цахим системээр дамжуулан борлуулж байгаа эсэхэд хяналт тавина.

2/16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2, 16.1.3, 16.1.4 дэх заалт:

“16.1.1.Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтад заасан баяжуулагч бэлдмэл, Хүнсний хууль эрх зүйн хороо, Европын холбооноос баталсан хүнсний нэмэлтийн жагсаалтад багтсан хүнсний нэмэлт, дотоодод үйлдвэрлэсэн болон импортын өсгөврийн хөрөнгийг дараах бичиг баримтыг үндэслэн бүртгэнэ:

16.1.1.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн албан хүсэлт;

16.1.1.2.гарал үүслийн гэрчилгээний хуулбар;

16.1.1.3.чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын гэрчилгээний хуулбар;

16.1.1.4.итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн;

16.1.1.5.өсгөврийн хөрөнгийн түүхий эд, бүтээгдэхүүний орц, найрлагын хувь хэмжээг тогтоосон тухай тэмдэглэл;

16.1.1.6.импортын өсгөврийн хөрөнгийн хувьд олон улсын стандартчиллын байгууллагаас тухайн өсгөврийн хөрөнгийн үйлдвэрлэлд олгосон хүчин төгөлдөр баталгаажуулалтын гэрчилгээний хуулбар.

16.1.2.Хүнсийг сайн дураар баяжуулахад ашиглах баяжуулагч бэлдмэл болон энэ хуулийн 16.1.1-д заасан жагсаалтад багтсанаас бусад хүнсний нэмэлтийг энэ хуулийн 16.1.1.1-16.1.1.4-т заасан баримт бичгээс гадна нийгмийн эрүүл мэндийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын судалгааны тайлангийн үр дүн, зөвлөмж, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн эрсдэлийн үнэлгээний багийн зөвлөмжийг тус тус үндэслэн бүртгэж, дугаар олгоно.

16.1.3.Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгийг бүртгэж, дор дурдсан байдлаар дугаар олгоно:

16.1.3.1.албан журмаар баяжуулах хүнсний баяжуулагч бэлдмэлийн бүртгэлийн дугаар нь ББА, сайн дураар баяжуулах хүнсний баяжуулагч бэлдмэлийн бүртгэлийн дугаар нь ББС гэж товчилсон 3 үсэг болон

бүртгэсэн оны сүүлийн 2 цифр, бүртгэлийн дугаар болох 4 оронтой тоо бүхий нийт 9 тэмдэгтээс бүрдсэн байх;

16.1.3.2.хүнсний нэмэлтийн бүртгэлийн дугаар нь ХН гэж товчилсон 2 үсэг болон олон улсын тоон системийн тухайн нэмэлтийн ангилалд харгалзах 4 оронтой дугаар, бүртгэсэн оны сүүлийн 2 цифр, бүртгэлийн дугаар болох 4 оронтой тоо бүхий 12 тэмдэгтээс бүрдсэн байх;

16.1.3.3.Өсгөврийн хөрөнгийн бүртгэлийн дугаар нь импортын болон дотоодын гэдгээс шалтгаалан ИӨХ, эсхүл ДӨХ гэж товчилсон 3 үсэг болон бүртгэсэн оны сүүлийн 2 цифр, бүртгэлийн дугаар болох 3 оронтой тоо бүхий 8 тэмдэгтээс бүрдсэн байх.

16.1.4.Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгийн бүртгэлийг дараах тохиодолд хүчингүй болгоно:

16.1.4.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгийг бүртгэлээс хасуулах тухай үндэслэл бүхий /үйлдвэрлэлийн технологи ажиллагаа, бүтээгдэхүүний орц, жор нь өөрчлөгдсөн гэх мэт/ хүсэлт гаргасан;

16.1.4.2.хүнсний нэмэлт нь Хүнсний хууль эрх зүйн хороо, Европын холбооноос баталсан хүнсний нэмэлтийн жагсаалтаас хасагдсан;

16.1.4.3.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн эрсдлийн үнэлгээний баг баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүртгэлийг хүчингүй болгох тухай санал ирүүлсэн;

16.1.4.4.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.4 дах заалтын дагуу хүнсний хяналтын улсын ахлах байцаагчийн гаргасан дүгнэлт ирүүлсэн.”

2 дугаар зүйл.Хүнсний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“16.1.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгийг доор дурдсаны дагуу улсын бүртгэлд бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлнэ:”

3 дугаар зүйл.Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “6.2-т” гэснийг “6¹ дүгээр зүйлд” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, 8.4 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**БАЯЖУУЛСАН ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Баяжуулсан хүнсний тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 10.4, 10.5 дахь хэсэг:

“10.2.Баяжуулсан хүнсний үйлдвэрлэлд ашиглах тоног төхөөрөмж, технологийн горим, баяжуулагч бэлдмэлийн чанар, аюулгүй байдлын баталгаажилт, туршилт хийсэн тухай тэмдэглэл, бүртгэлийг үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө харьяалах нутаг дэвсгэр дэх хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллагад мэдээлнэ.

10.3.Үйлдвэрийн хүчин чадал, албан журмаар баяжуулах хүнсний нэр төрөлд тавигдах стандарт, технологийн онцлогт тохирсон тоног төхөөрөмж ашиглан үйлдвэрлэл эрхлэх бөгөөд эрх бүхий байгууллагын баталгаажуулсан хэмжих хэрэгслийг ашиглана.

10.4.Хүнс баяжуулах үйлдвэрлэлийн явцад өдөр тутам дотоодын хяналт хэрэгжүүлэх ба эцсийн бүтээгдэхүүнийг улирал тутам хөндлөнгийн лабораторид шинжлүүлэн баталгаажуулна.

10.5.Баяжуулсан хүнсний чанар, аюулгүй байдал стандартын шаардлага хангасан эсэхийг магадлах лабораторийн шинжилгээ, зах зээлээс буцаан болон татан авах, устгахтай холбоотой зардлыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хариуцна.”

2/7 дугаар зүйлийн 7.2.7 дахь заалт:

“7.2.7.сайн дурын үндсэн дээр шинээр хүнс баяжуулах тохиолдолд баяжуулагч бэлдмэлийн болон баяжуулсан хүнсний стандарт батлуулсан байх;”

2 дугаар зүйл.Баяжуулсан хүнсний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтын “явуулах” гэсний дараа “хадгалах, тээвэрлэх” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Баяжуулсан хүнсний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7 дахь заалтын дугаарыг “7.2.8” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “хэрэгжүүлнэ.” гэснийг “хэрэгжүүлэх ба хүнс баяжуулах үйлдвэрийн технологи горимын мөрдөлт, тоног төхөөрөмжийн бүрдэл, баяжуулсан хүнс, баяжуулагч бэлдмэлийн чанар, аюулгүй байдлын баталгаажилт, шошго, батлагдсан тэмдэг, тэмдэглэгээ, сав, баглаа боодлын битүүмжлэл, хадгалах, тээвэрлэх нөхцөл, мэргэжилтэй ажилтны нөөц, холбогдох хууль, стандартаар хүнс үйлдвэрлэгчид тавигдах шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18.1.6-д заасан мэдээллийн санд оруулна.” гэж, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийн “оруулахыг зөвшөөрч, экспортын гэрчилгээ, импортын мэдэгдлийг олгоно.” гэснийг “оруулна.” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Баяжуулсан хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**НЯЛХ, БАЛЧИР ХҮҮХДИЙН ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, АРХИДАН
СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/5¹ дүгээр зүйл

“5¹ дүгээр зүйл. Дуудлага худалдаа зохион байгуулах журам

5^{1.1}. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дуудлага худалдааг дараах үе шаттай зохион байгуулна:

- 5^{1.1.1}. дуудлага худалдааны оролцогчийн сонгон шалгаруулалт;
- 5^{1.1.2}. цахим дуудлага худалдаа.

5^{1.2}. Энэ хуулийн 5^{1.1.1}-д заасан сонгон шалгаруулалтад Монгол Улсад бүртгэлтэй ашгийн төлөө хуулийн этгээд оролцоно.

5^{1.2}. Дуудлага худалдаанд оролцогчийн сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай зарыг хуулийн этгээдийн хүсэлт хүлээн авч эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудаст байршуулна.

5^{1.3}. Сонгон шалгаруулалтын зард хүсэлт хүлээн авч эхлэх, дуусах хугацаа, хүсэлт ирүүлэх зааварчилгаа, олгох тусгай зөвшөөрлийн ангилалд үндэслэсэн дуудлага худалдааны анхны үнэ, өсгөн хэлэх үнийн хязгаар, цахим хаяг болон байршлыг тодорхой заана.

5^{1.4}. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй хуулийн этгээд нь доор дурдсан баримт бичгийг цахимаар хүргүүлнэ:

5^{1.4.1}. тухайн хуулийн этгээдийн оршин байгаа газрын албан ёсны хаяг, цахим шуудангийн хаяг, харилцах утасны дугаартай тамга, тэмдэг бүхий албан хүсэлт;

5^{1.4.2}. Энэ хуулийн 6.1.3-т заасан үйлдвэрийн төслийн баримт бичиг;

5^{1.4.3}. санхүүгийн чадавхыг тодорхойлсон харилцагч банкны мэдэгдэл, эсхүл нотлох бусад баримт бичиг;

5^{1.4.4}. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

5^{1.4.5}. татварын өргүй тухай татварын байгууллагын тодорхойлолт;

5^{1.4.6}. аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон хуулийн дагуу татвар, хураамж, төлсөн талаарх мэдээлэл.

5^{1.5}.Дуудлага худалдаа зохион байгуулах үүрэг бүхий 7-9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулна.

5^{1.6}.Энэ хуулийн 5^{1.5}-д заасан ажлын хэсгийн дарга, гишүүн нь дараах эрх, үүрэгтэй:

5^{1.6.1}.энэ хуулийн 5^{1.4}-т заасан баримт бичгийн бүрдэл дутуу бол тухайн хуулийн этгээдийг сонгон шалгаруулалтад оруулахаас татгалзах;

5^{1.6.2}.шаардлагатай тохиолдолд тухайн хуулийн этгээдийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, нэмэлт материал гаргуулж авах;

5^{1.6.3}.энэ хуулийн 5^{1.17}-д заасан үндэслэлээр дуудлага худалдааг дахин явуулах шийдвэр гаргах;

5^{1.6.4}.ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй нөхцөл үүссэн тохиолдолд энэ талаар мэдэгдэж, дуудлага худалдааг зохион байгуулах үйл ажиллагаанд оролцохоос татгалзах;

5^{1.6.5}.дуудлага худалдаанд оролцогчийн бизнесийн нууцыг бусдад мэдээлэхгүй, шударга өрсөлдөх тэгш боломжоор хангах, бусдад давуу байдал олгохгүй байх;

5^{1.6.6}.дуудлага худалдаа явуулах үеийн программ хангамж, цахим системийн хэвийн ажиллагаа, хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан эсэхэд хяналт тавих;

5^{1.6.7}.дуудлага худалдааны нэгдсэн тайлан, ялагчийн талаарх мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх.

5^{1.7}.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтыг хүсэлт хүлээн авах хугацаа дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан зохион байгуулж, тэнцсэн хуулийн этгээдэд дуудлага худалдаанд оролцох тухай урилга, тэнцээгүй хуулийн этгээдэд дуудлага худалдаанд оролцуулахаас татгалзсан тухай мэдэгдлийг тус тус цахимаар хүргүүлнэ.

5^{1.8}.Сонгон шалгаруулалтад тэнцээгүй хуулийн этгээд нь дуудлага худалдаанд оролцуулахаас татгалзсан тухай мэдэгдлийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд уг мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын 5 өдөрт багтаан хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гомдол гаргаж болно.

5^{1.9}.Энэ хуулийн 5^{1.8}-д заасан гомдол гаргах хугацаа өнгөрсөн, эсхүл гомдлыг шийдвэрлэснээс хойш ажлын 10 өдрийн дотор цахим дуудлага худалдааг зохион байгуулна.

5^{1.10}.Сонгон шалгаруулалтад тэнцсэн хуулийн этгээд хүсэлт гарган, дуудлага худалдааны анхны үнийн 10 хувьтай тэнцэх хэмжээний дэнчинг урилгад заасан дансанд байршуулснаар цахим дуудлага худалдаанд оролцох эрх үүснэ.

5^{1.11}.Цахим дуудлага худалдааны оролцогч нь үнэ өсгөх саналыг хэдэн ч удаа гаргаж болно.

5^{1.11}.Цахим дуудлага худалдаанд үнийн санал өгснөөс хойш хоёр минутын дотор бусад оролцогч өмнөх оролцогчийн саналаас өссөн үнийн санал өгөөгүй тохиолдолд дуудлага худалдааг дуусгаж, хамгийн өндөр үнийн санал өгсөн оролцогч дуудлага худалдааны ялагч болно.

5¹.12.Ажлын хэсэг нь дуудлага худалдааны явц, үр дүнг тэмдэглэл хөтөлж баталгаажуулна.

5¹.13.Дуудлага худалдааны ялагч нь өөрийн санал болгосон эцсийн үнийг дуудлага худалдаа дууссанаас хойш 72 цагийн дотор урилгад заасан дансанд төлөх үүрэгтэй бөгөөд дэнчинг дуудлага худалдааны үнэд оруулан тооцно.

5¹.14.Дуудлага худалдаанд оролцогч нь ялагч болоогүй тохиолдолд урьдчилан төлсөн дэнчинг дуудлага худалдаа дууссанаас хойш ажлын 2 өдрийн дотор аливаа шимтгэлгүйгээр буцаан олгоно.

5¹.15.Энэ хуулийн 5¹.10-т заасны дагуу дэнчин байршуулсан боловч дуудлага худалдаанд оролцоогүй тохиолдолд тухайн оролцогчийг татгалзсанд тооцож, дуудлага худалдааны тэмдэглэлд тусган, дэнчинг буцаан олгоно.

5¹.16.Дуудлага худалдааны ялагч нь согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авах эрхээсээ татгалзсан, дуудлага худалдааны оролцогчид анхны үнэд хүрэх санал гаргаагүйгээс дуудлага худалдаа амжилтгүй болсон тохиолдолд дэнчинг буцаан олгохгүй.

5¹.17.Ажлын хэсэг дараах тохиолдолд дуудлага худалдааг дахин явуулна:

5¹.17.1.дуудлага худалдаанд нэг этгээд оролцсон;

5¹.17.2.зөвхөн нэг үнийн санал өгсөн;

5¹.17.3.анхны үнэд хүрэх санал гараагүй;

5¹.17.4.дуудлага худалдааны ялагч тогтоосон хугацаанд дуудлага худалдаанд санал болгосон үнийг бүрэн төлөөгүй;

5¹.17.5.дуудлага худалдааны ялагч согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авах эрхээсээ татгалзсан;

5¹.17.6.хууль зөрчсөн, хууль бус дуудлага худалдаа явуулсныг шүүхээр тогтоосон;

5¹.17.7.хуульд заасан бусад тохиолдолд.

5¹.18.Дуудлага худалдааг дахин явуулах хугацааг ажлын хэсэг тогтоох бөгөөд энэ хуулийн 5¹.7-д заасан сонгон шалгаруулалтад тэнцсэн этгээдэд энэ тухай зарыг дахин дуудлага худалдаа явуулах өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө хүргэнэ.

5¹.19.Ажлын хэсэг нь дуудлага худалдаанд оролцохоор ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичиг, дуудлага худалдааны тэмдэглэл, нэгдсэн тайланг бэлтгэн архивын нэгж үүсгэн хадгалуулна.

5¹.20.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавина.”

2/12 дугаар зүйлийн 12.10, 12.11 дэх хэсэг:

“12.10.Согтууруулах ундааны шошгоны нийт талбайн 10 хүртэл хувьд энэ хуулийн 12.1.8-д заасан анхааруулгыг зураг, эсхүл бичвэр байдлаар байрлуулах ба шошгонд эрүүл мэндийн мэдэгдэл байрлуулахыг хориглоно.

12.11.Энэ хуулийн 12.10-т заасан анхааруулгын зураг, бичвэр нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хөнөөл, гаж нөлөө үзүүлэх, жирэмсэн, тээврийн хэрэгсэл жолоодож байгаа болон 21 насанд хүрээгүй хүн хэрэглэхийг хориглох агуулгатай байна.”

3/34 дүгээр зүйлийн 34.2, 34.3, 34.4, 34.5, 34.6, 34.7, 34.8, 34.9, 34.10, 34.11, 34.12, 34.13, 34.14, 34.15, 34.16, 34.17, 34.18, 34.19, 34.20, 34.21, 34.22, 34.23 дахь хэсэг:

34.3.Аж ахуйн нэгж, байгууллага тухайн жилд ашиглах хүнсний болон техникийн спиртийн захиалгыг 12 дугаар сарын 15-ны дотор өөрийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу харьяалах аймаг, нийслэлийн хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эмийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мал, амьтны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

34.4.Энэ хуулийн 34.3-т заасан захиалгын хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

34.4.1.улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

34.4.2. товч танилцуулга;

34.4.3.харьяалах татварын албаны санал, татварын өргүй талаар тодорхойлолт;

34.4.4.өмнөх оны спирт захиалгын болон зарцуулалтын тайлан.

34.5.Энэ хуулийн 34.3-т дурдсан төрийн захиргааны байгууллага нь тухайн жилд ашиглах хүнсний болон техникийн зориулалт бүхий спиртийн захиалгыг аж ахуйн нэгж, байгууллага тус бүрээр гаргаж, жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор дор дурдсан байгууллагуудад тус тус хүргүүлнэ:

34.5.1.хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэглэх хүнсний болон техникийн спиртийн захиалгыг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

34.5.2.хүн эмнэлэг, эм, бэлдмэлийн үйлдвэрт хэрэглэх хүнсний болон техникийн спиртийн захиалгыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

34.5.3.мал эмнэлэг, малын эм, бэлдмэлийн үйлдвэрт хэрэглэх хүнсний болон техникийн спиртийн захиалгыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад.

34.6.Аймаг, нийслэлийн хүнсний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь өөрийн аймаг, нийслэл дэх спиртийн үйлдвэрийн олгосон спиртийн болон спиртийн гарцын тухайн жилийн тэнцлийн тайланг аж ахуйн нэгж, байгууллага бүрээр гаргаж, жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны дотор хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

34.7.Энэ хуулийн 34.6-д заасан спиртийн тэнцлийн тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна:

34.7.1.түүхий эдийн хэмжээ, чанарын үзүүлэлт;

34.7.2. тухайн жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ спиртийн альфа, тансаг, онцгой, дээд, техникийн гэсэн ангиллаар;

34.7.3. тухайн жилд устгалд оруулсан спиртийн хэмжээ хүнсний болон техникийн спирт тус бүрээр;

34.7.4. спиртийн шаарны хэмжээ хуурай, шингэн хэлбэрээр.

34.8. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь тухайн жилийн хэрэгцээт спиртийн захиалгыг хянаж нэгтгэн, жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны дотор хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

34.9. Аж ахуйн нэгж, байгууллагад тухайн жилд олгох спиртийн хуваарийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны дотор баталж, энэ хуулийн 34.5.1, 34.5.2, 34.5.3-т заасан байгууллага болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, спиртийн үйлдвэрт хүргүүлнэ.

34.10. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 34.9-д заасан спиртийн хуваарьт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

34.11. Аж ахуйн нэгж, байгууллага нь спиртийн хуваарь батлагдсанаас хойш шинээр байгуулагдсан, эсхүл хуваарьт спиртийн үйлдвэрээс спирт авах боломжгүй болсон, эсхүл спиртийн нэмэлт хэрэгцээ бий болсон тохиолдолд спиртийн захиалгыг энэ хуулийн 34.3-т заасны дагуу гаргаж болно.

34.12. Нэмэлт захиалгын хүсэлтийг энэ хуулийн 34.5, 34.6, 34.8, 34.9-д заасны дагуу улирал тутам шийдвэрлэнэ.

34.13. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн жилийн спиртийн хуваарьт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд энэ талаарх мэдээллийг энэ хуулийн 34.9-д заасан байгууллагуудад хуваарь батлагдсанаас хойш ажлын 7 өдөрт багтаан хүргүүлнэ.

34.14. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хуваариас гадуур дур мэдэн хуваарилалт, шилжүүлэлт, олголт хийхийг хориглоно.

34.15. Спиртийн захиалга авах, хуваарилах асуудлыг цаасан болон цахим хэлбэрээр шийдвэрлэж болно.

34.16. Спирт үйлдвэрлэгч нь хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан спиртийн хуваарийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагад спирт олгоно.

34.17. Спирт үйлдвэрлэгч нь хүнсний болон техникийн спиртийн ул мөрийг мөрдөн тогтоох, буцаалт болон татан авалт, дотоод хяналт, шалгалтын бүртгэл хөтөлнө.

34.18.Спирт үйлдвэрлэгч нь зориулалтын саванд савласан байх ба бүтээгдэхүүний шошго, дагалдах хуудсанд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан мэдээллийг тусгана.

34.19.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хуваарьт орсон спиртийн үйлдвэрүүдтэй гэрээ байгуулна.

34.20.Спирт үйлдвэрлэгч нь дотоод хяналтын журам баталж хэрэгжүүлнэ.

34.21.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулсан, түвшин заагч, спиртийн зарцуулалт хэмжигч хэрэгсэл бүхий битүү системээр ачаалах, буулгах боломжтой, битүүмжлэгдсэн төхөөрөмжид спиртийг хадгалж, бүртгэл хөтөлнө.

34.22.Энэ хуулийн 34.3-т заасан төрийн захиргааны байгууллага нь спирт хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага спиртийг хуваарийн дагуу татан авч байгаа эсэх, олгосон спиртийг зориулалтын дагуу зарцуулж буй эсэхэд хяналт тавина.

34.23.Спиртийн үйлдвэрийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хүнсний хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавина.

4/38 дугаар зүйлийн 38.8, 38.9, 38.10, 38.11 дэх хэсэг:

38.8.Энэ хуулийн 38.1-д заасан цахим сан нь дараах мэдээллийг агуулсан байна:

38.8.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуулийн 38.4-т заасан холбогдох мэдээллээс гадна дараах мэдээлэл:

- 38.8.1.1.үйлдвэрлэгчийн нэр, регистрийн дугаар;
- 38.8.1.2.үйлдвэрлэгчийн хаяг байршил, холбоо барих утас;
- 38.8.1.3.тусгай зөвшөөрлийн төрөл, хугацаа;
- 38.8.1.4.бүтээгдэхүүний нэр, төрөл;
- 38.8.1.5.зураасан код.

38.8.2.Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуулийн 38.4-т заасан холбогдох мэдээллээс гадна дараах мэдээлэл:

- 38.8.2.1.импортлогчийн нэр, регистрийн дугаар;
- 38.8.2.2.импортлогчийн хаяг байршил, холбоо барих утас;
- 38.8.2.3.тусгай зөвшөөрлийн төрөл, хугацаа;
- 38.8.2.4.бүтээгдэхүүний нэр, төрөл;
- 38.8.2.5.барааг тодорхойлох, кодлох, уялдуулсан системийн ангиллын код, зураасан код;

- 38.8.2.6.импортолсон тоо, хэмжээ;
- 38.8.2.7.импортолсон хилийн боомтын нэр;
- 38.8.2.8.гаалийн бүрдүүлэлтийн горимын код;

38.8.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуулийн 38.4-т заасан холбогдох мэдээллээс гадна дараах мэдээлэл:

38.8.3.1.согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, регистрийн дугаар;

38.8.3.2.тусгай зөвшөөрлийн хаяг, байршил холбоо барих утас;

38.8.3.3.тусгай зөвшөөрлийн төрөл, хугацаа;

38.8.3.4.бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ;

38.8.3.5..зураасан код.

38.8.4.уламжлалт технологиор согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуулийн 38.4-т заасан холбогдох мэдээллээс гадна дараах мэдээлэл:

38.8.4.1.үйлдвэрлэгчийн нэр, регистрийн дугаар;

38.8.4.2.үйлдвэрлэгчийн хаяг байршил, холбоо барих утас;

38.8.4.3.тусгай зөвшөөрлийн төрөл, хугацаа;

38.8.4.4.бүтээгдэхүүний нэр, төрөл;

38.8.4.5.зураасан код.

38.9.Энэ хуулийн 38.8.1.1-38.8.1.3, 38.8.2.1-38.8.2.3-т заасан мэдээллийг энэ хуулийн 38.1-д заасан цахим сангаас, 38.8.1.4, 38.8.1.5, 38.8.3.4, 38.8.3.5, 38.8.4.4, 38.8.4.5-д заасан мэдээллийг энэ хуулийн 38.3-т заасан сангаас, 38.8.2.4-38.8.2.8-д заасан мэдээллийг гаалийн үйл ажиллагааны мэдээллийн сангаас, 38.8.3.1-38.8.3.3, 38.8.4.1-38.8.4.3-т заасан мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн системээр дамжуулан авна.

38.10.Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийн санг эрх бүхий албан тушаалтан албан хэрэгцээнд ашиглана.

38.11.Мэдээллийн сан дахь хуулийн этгээдийн нууцтай холбоотой мэдээллийг задруулах, мэдээллийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор ашиглах, бусдад дамжуулахыг хориглоно.

5/12 дугаар зүйлийн 12.1.9 дэх заалт:

“12.1.9.хадгалах хугацаа, эсхүл хэрэглэж дуусах хугацаа.”

6/15¹ дүгээр зүйлийн 15¹.1.5, 15¹.1.6, 15¹.1.7 дахь заалт:

“15¹.1.5.30 хоногоос доошгүй хугацаанд дүрс бичлэг хадгалах, байнгын ажиллагаатай стандартын шаардлага хангасан камер, техник, хэрэгсэл суурилуулсан талаарх баримт;

15¹.1.6.Өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх дотоод хяналтын журам;

15¹.1.7.Шөнийн цагаар үйлчилгээ явуулах тохиолдолд барилга байгууламжаас 10 метрээс доошгүй зайд гэрэлтүүлэх төхөөрөмжийг байршуулсан талаарх баримт.”

7/38 дугаар зүйлийн 38.4.10 дахь заалт:

“38.4.10.үйлдвэрлэлийн шугамын оролт, гаралтыг тоолуурын тоо, заалт.”

2 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “ундааны” гэсний дараа “үйлдвэрийн хүчин чадал, үйлдвэрлэх согтууруулах ундааны танилцуулга, эдийн засгийн тооцоо агуулсан” гэж, мөн зүйлийн 6.1.7 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэсний өмнө “үйлдвэрлэлийн шугам, тоног төхөөрөмж, технологийн мэдээлэл болон” гэж, мөн зүйлийн 6.1.9 дэх заалтын “эх үүсвэр,” гэсний дараа “санхүүгийн тооцоолол,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14.7, 16.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг:

“14.7.Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, улсын байцаагч хяналт тавина.”

2/11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэг:

“11.6.Энэ хуулийн 11.1-д заасан тоног төхөөрөмж нь энэ хуулийн 38.1, 38.3-т заасан мэдээллийн цахим санд холбогдсон байх бөгөөд тоног төхөөрөмж нь холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн байна.”

3/16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг:

“16.6.Кафе болон спорт тоглоомын үйлчилгээ бүхий баарны үйл ажиллагаа эрхлэгч нь 18-аас дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглоно.”

4 дүгээр зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “худалдаа зохион байгуулах журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэснийг “худалдааг энэ хуулийн 5¹ дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулна.” гэж, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “мэдээллийг” гэснийг “мэдээлэл, барааны болон олон улсын үзэсгэлэн, уралдаанаас авсан шагналын тэмдэг зэргийг” гэж, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “бүртгэл болон холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн” гэснийг “бүртгэл, мэдээллийн” гэж, мөн зүйлийн 38.2 дахь хэсгийн “байна.” гэснийг “байх бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл солилцох боломжтой байна.” гэж, мөн зүйлийн 38.6 дахь хэсгийн “санг бүрдүүлэх, ашиглах үйл ажиллагааг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.” гэснийг “сан нь Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд цахим сангийн мэдээллийг холбогдох төрийн байгууллагууд албан хэрэгцээнд ашиглах боломжтой байна.” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.2, 12 дугаар

зүйлийн 12.3, 24 дүгээр зүйлийн 24.4, 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2, 38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тамхины хяналтын тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг нэмсүгэй:

1/6¹ дүгээр зүйл:

“6¹ дүгээр зүйл. Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаанд тавих хяналт

6^{1.1}. Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь тамхины үйлдвэрлэлийн үе шат болон импортын үйл ажиллагааны явцад эрсдэлд суурилсан хяналт, тандалт, эрсдэлийн үнэлгээ хийж, зөрчлийн шалтгааныг тогтоон таслан зогсоож, үр дүнг олон нийтэд болон холбогдох байгууллагад шуурхай мэдээлнэ.

6^{1.2}. Гаалийн байгууллага тамхи импортлогчдод гаалийн үнэ, үнэлгээ, барааны ангиллыг тодорхойлох, онцгой албан татварыг ногдуулах зорилгоор гаалийн магадлан шинжилгээнд хамруулж, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, энэ хуулийн дагуу хяналт тавьж, холбогдох мэдээллийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон татварын байгууллагад мэдээлнэ.

6^{1.3}. Цагдаа, татварын байгууллага нь хариуцсан чиг үүргийн хүрээнд энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.

6^{1.4}. Тамхины түүхий эд, бүтээгдэхүүний стандарт, аюулгүй байдлын үзүүлэлтийн шаардлага хангаагүй, буруу шошголсон, хуурамч бүтээгдэхүүн болохыг дотоодын болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар тогтоосон, импортолсон тамхи, түүхий эд, экспортолсон бүтээгдэхүүний талаархи сэрэмжлүүлэг олон улсын байгууллагын мэдээллийн сүлжээгээр мэдээлэгдсэн тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрээр тамхины түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлээс татан авч, холбогдох хууль тогтоомж, зохих журмын дагуу устгана.

6^{1.5}. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ тамхи худалдах үйл ажиллагаанд хяналт тавьж, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авч, дүнг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад жил бүр мэдээлнэ.

6^{1.6}. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага болон төрийн бус байгууллага нь олон нийтийн хяналтыг өөрсдөө, эсхүл олон нийтийн байцаагчтай гэрээ байгуулан, хөндлөнгийн хяналт тавих, эсхүл холбогдох байгууллагатай хамтарсан хяналт шалгалт хийх ба мэдээлэл, саналаа эрх бүхий байгууллагуудад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

6¹.7.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь тамхи худалдах үйл ажиллагааны зөрчилтэй холбоотой мэдээлэл, гомдол, саналаа харьяалах сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

6¹.8.Аж ахуйн нэгж, байгууллага нь Тамхины хяналтын суурь конвенцийн 8 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамж, “Тамхины утаанд өртөхөөс хамгаалах тухай” зарчмыг хүндэтгэн баримтална. Тамхины хяналтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтын үед гарсан зөрчлийн баримт бүхий мэдээллийг харьяалах баг, хорооны Засаг даргад болон цагдаагийн байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.”

2/6 дугаар зүйлийн 6.10, 6.11 дэх хэсэг:

“6.10.Тамхины үйлдвэрлэлд дараах шаардлагыг тавина:

6.10.1.мэргэжлийн байгууллагын баталгаажуулсан тамхины үйлдвэрлэлийн барилга байгууламжийн зураг төсөлтэй байх;

6.10.2.тамхины үйлдвэр нь бүтээгдэхүүний нэр төрөлд тавигдах стандарт, шаардлагад тохирсон технологийн шат дамжлага бүхий тоног төхөөрөмж, технологийн заавартай байх;

6.10.3. Тамхины үйлдвэр нь үйл ажиллагаандаа үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын дотоод хяналт, удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байх;

6.10.4.тамхины түүхий эд, үйлдвэрлэлийн дамжлага дундын болон эцсийн бүтээгдэхүүнд шинжилгээ хийх зориулалт бүхий лабораторитой байх ба технологийн шат дамжлагын болон түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх.

6.10.5.тамхины үйлдвэрлэл эрхлэх мэргэжлийн болон мэргэшсэн хүний нөөцтэй байх;

6.10.6.тамхи экспортлох эрх бүхий байгууллага буюу экспортлогч улсын нийлүүлэгч, үйлдвэрлэгчээс олгосон чанарын баталгаа, гэрчилгээ бүхий түүхий эд, материал, бодис, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд ашиглах;

6.10.7.тамхины үйлдвэрийн үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоох, тоног төхөөрөмж, ажлын байр, хаяг өөрчлөгдөх тохиолдолд үйлдвэрлэл эрхлэгч нь хяналтын байгууллага болон тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад мэдэгдэх.

6.10.8.Стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх;

6.10.9.адилхан орц, найрлагатай болон нэг төрлийн түүхий эд бүхий тамхийг олон нэрээр үйлдвэрлэхгүй байх.

6.11.Тамхи импортлоход дараах шаардлага тавина:

6.11.1.Тамхи импортлохоос өмнө эрх бүхий байгууллагаар эрсдэлийн үнэлгээг хийлгэж, тамхины чанар, аюулгүй байдал, сав баглаа, боодол нь стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд тамхины нэр төрөл тус бүрээр энэ хуулийн эрүүл мэндийн дүгнэлт гаргуулсан байх;

6.11.2.Эрүүл мэндийн дүгнэлтийг гаргахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

6.11.2.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

6.11.2.2.түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах талаар экспортлогч орны үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээний хуулбар;

6.11.2.3.экспортлогч, импортлогч улсын эрх бүхий байгууллагаас үйлдвэрлэгчид олгосон зохистой дадал, удирдлагын хяналтын тогтолцоо (GAP, GHP, GMP, ISO, HACCP гм)-г нэвтрүүлсэн тухай бичиг баримтын хуулбар;

6.11.2.4.экспортлогч улсын эрх бүхий байгууллага болон үйлдвэрлэгчээс бүтээгдэхүүн (гарал үүсэл, ургамлын эрүүл ахуй, чанар болон эрүүл мэндийн гэрчилгээ)-д олгосон баталгаажуулалтын бичиг баримт;

6.11.2.5.савлах, тээвэрлэх, хадгалах горим, шаардлагад нийцсэн шинжилгээнд хүрэлцэхүйц хэмжээний түүхий эд, бүтээгдэхүүний дээж;

6.11.2.6.Монгол Улсын нутаг дэвсгэрт импортлох тамхины хайрцаг, сав баглаа боодол дээр үйлдвэрлэсэн улс, он, сар, өдөр, үйлдвэр, импортлогчийн нэр, тамхины найрлаганд агуулагдах бохь, никотин, бусад хорт бодисын хэмжээ болон дуусгавар болох хугацааг заасан шошгоны загварын талаар экспортлох эрх бүхий байгууллага буюу экспортлогч улсын нийлүүлэгч, үйлдвэрлэгч байгууллагын тодорхойлолт, Монгол Улсад худалдаалахыг зөвшөөрсөн тухай тэмдэглэл.

6.11.3.импортлох тамхийг хадгалах стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх;

6.11.4.тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;

6.11.5.импортлох тамхины нэр төрөл, тоо хэмжээгээр онцгой албан татварын тэмдгийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас авсан байх;

6.11.6.тамхи импортлохоос өмнө Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасны дагуу импортын мэдэгдэл авсан байх.”

2 дугаар зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

**ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Тариалангийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “бодлого, дунд хугацааны хөтөлбөрт” гэснийг “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт, дунд хугацааны баримт бичигт” гэж, мөн зүйлийн 21.4 дэх хэсгийн “тооцох аргачлалыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг “тооцоход холбогдох стандартыг баримтална.” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Тариалангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 20 дугаар зүйлийн 20.5, 21 дүгээр зүйлийн 21.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮР, СОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Таримал ургамлын үр, сортын тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/14¹ дүгээр зүйл:

“14¹ дүгээр зүйл.Сортыг шинэ, ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох журам

14¹.1.Сортыг шинэ, ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбооноос баталсан тухайн таримлын туршилтын арга зүйн дагуу тогтооно.

14¹.2.Энэ хуулийн 14¹.1-д заасан арга зүй байхгүй тохиолдолд сортын шинэ, ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох туршилтын арга зүйг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага боловсруулж, Үр, сортын зөвлөлөөр батлуулна.

14¹.2.Энэ хуулийн 14¹.2-т заасан арга зүйг Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбоонд болон нийтэд мэдээлнэ.

14¹.3.Сортыг шинэ, ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл ажиллагааг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага гүйцэтгэнэ.

14¹.4.Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбооны гишүүн оронтой хамтран ажиллах гэрээтэй бол шинэ сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл ажиллагааг дараах тохиолдолд тухайн гадаад орны байгууллагаар гүйцэтгүүлж болно:

14¹.4.1.тухайн улсын ургамлын шинэ сортыг хамгаалах эрх бүхий байгууллагаас шинэ сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоох үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх авсан байх;

14¹.4.2.тухайн улсын агро-экологийн нөхцөл нь Монгол Улстай ижил төстэй байх.

14¹.5.Энэ хуулийн 14¹.3-т заасан тохиолдолд мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага тухайн улсын эрх бүхий байгууллагад сортын бүтээгчийн эрхийн хамгаалалт авах тухай хүсэлтийг техникийн асуумжийн хуулбарын хамт илгээнэ.

14¹.6.Сортын бүтээгч нь туршилтын арга зүйд заасан хэлбэр, хэмжээ, холбогдох стандартын шаардлага хангасан сортын материалыг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагын заасан хугацаа, байршилд хүргүүлнэ.

14¹.7.Туршилтад шаардагдах үрийг ариутгаагүй, физик, хими, биологийн үйлчлэлд оруулаагүй байна.

14¹.8.Туршилтыг ижил нөхцөлд 2-оос доошгүй удаа хийх ба дараалсан мөчлөгтэй байна. Шаардлагатай тохиолдолд 3 дахь туршилтыг хийж болно.

14¹.9.Олон наст, модлог ургамлын хувьд туршилтыг сортын бүтээгчийн талбайд хийнэ.

14¹.10.Туршилт явуулсан байршилд шинэ сортын ялгаатай шинж тэмдэг илрэхгүй тохиолдолд байршлыг өөрчилнө.

14¹.11.Туршилтыг явуулахдаа хүсэлт гаргасан шинэ сортыг хяналтын сортуудтай харьцуулах замаар ялгаатай байдлыг тодорхойлно.

14¹.12.Хяналтын сортод дараах сортууд байна:

14¹.12.1.Монгол Улсын сорт;

14¹.12.2.ижил төстэй бүс нутгийн сорт;

14¹.12.3.хүсэлт гаргагчийн санал болгосон сорт;

14¹.12.4.эрлийз сортын эцэг, эх сорт;

14¹.12.5.бусад шалгах сорт;

14¹.12.6.Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбооны

жишээ сорт.

14¹.13.Сортыг түүний гадаад шинж тэмдгээр үнэлэх ба дараах төрөлтэй байна:

14¹.13.1.бүлэг ургамал, ургамлын хэсгүүдэд нэг удаагийн хэмжилт;

14¹.13.2.нэг ургамал, ургамлын хэсгийн хэмжилт;

14¹.13.3.бүлэг ургамал, ургамлын хэсгийн нэг удаагийн ажиглалт;

14¹.13.4.нэг ургамал, ургамлын хэсгийн ажиглалт;

14¹.14.Ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон байдлын туршилтын хэмжилтийг 3 болон түүнээс дээш мэргэжлийн хүн гүйцэтгэнэ.

14¹.15.Хүсэлт ирүүлсэн сортыг хяналтын сортоос илэрхий болон тодорхой ялгаатайг тогтооно.

14¹.16.Гурван ургамлын мөчлөгийн 2 мөчлөгт нь, эсхүл 2 мөчлөгт дараалан ижил утга гарсан байвал ялгаатай байдал илэрхий байна гэж үзнэ.

14¹.17.Шинэ сортын шинж чанарыг тодорхойлохдоо ажиглалт, хэмжилтийг хослуулан хийхэд ижил утгатай байвал ялгаатай байдал тодорхой байна гэж үзнэ.

14¹.18.Шинж тэмдэг бүрийг тусад нь тодорхойлно. Урт, өргөн зэрэг зарим тоон шинж тэмдгийг хамтад нь тодорхойлж болно.

14¹.19.Сортын шинж тэмдгийн ажиглалтын үнэлгээ эргэлзээтэй байвал хэмжилтийн үнэлгээний дүнг зөв гэж үзнэ.

14¹.20.Сортын ялгаатай байдлыг тогтоох явцад илэрч буй ажиглагдаж, хэмжигдсэн аливаа ялгааг тухай бүрт нь бүртгэж хөтөлнө.

14¹.21.Сортын ялгаатай шинж тэмдгийг тохирох хөгжлийн үе шатанд илрүүлж, зургаар баримтжуулна.

14¹.22.Сортын жигдэрсэн байдлыг үнэлэхдээ тухайн сортоос өөр хэв шинж агуулсан ургамал байгаа эсэхийг тодорхойлно.

14¹.23.Өөр хэв шинж агуулсан ургамал байх дээд хэмжээг тухайн таримлын туршилтын арга зүйд тусгана.

14¹.24.Солбицон тоос хүртдэг, эсхүл 2 болон түүнээс дээш шаталсан эрлийз сортын хувьд популяцийн стандарт хазайлтын хэмжээг таримлын туршилтын арга зүйд тусгана.

14¹.25.Сортын тогтворжсон байдлыг тухайн сортыг 2-оос доошгүй жил давтан тариалах замаар тодорхойлно.

14¹.26.Шаардлагатай тохиолдолд сортын тогтворжсон байдлыг үнэлэхдээ тухайн сортын онцлогоос хамаарч дараагийн үе удмыгургуулах, эсхүл шинэ үрийн материалыг туршилтад оруулах замаар өмнө нийлүүлэгдсэн сортын материалтай харьцуулж ижил шинж тэмдгийг хадгалж байгаа эсэхийг магадална.

14¹.27.Туршилтын эхний жилийн үр дүнгээр ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон байдлын эхлэлийн тайланг гаргах ба тайлан нь туршилтын явцад илэрсэн асуудлыг багтаасан ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон байдлыг шалгах үйл явцын үр дүнгийн мэдээллийг агуулсан байна.

14¹.28.Туршилтын явцын болон эцсийн тайланг Ургамлын шинэ сортыг хамгаалах олон улсын холбооны шаардлагад нийцүүлэн боловсруулах ба тайлангийн үр дүн эерэг гарсан тохиолдолд сортын тодорхойлолтыг хавсаргана.

14¹.29.Ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон байдлын туршилтыг гүйцэтгэсэн байгууллага энэ энэ хуулийн 14¹.27, 14¹.28-д заасан тайланг сортын тодорхойлолтын хамт Үр, сортын зөвлөлд хүргүүлнэ.”

2/14² дугаар зүйл:

“14² дүгээр зүйл.Сортын бүтээгчийн эрх авах хүсэлт гаргах, хүсэлтэд шүүлт хийх журам

14².1.Сортын бүтээгч хэдэн ч сорт дээр хүсэлт гаргаж болох бөгөөд сорт бүрт тус тусдаа хүсэлт гаргана.

14².2.Сортын бүтээгч хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

14².2.1.сортын тодорхойлолт. Сортын тодорхойлолт нь тусгайлсан техникийн асуулт бүхий сортын дэлгэрэнгүй тодорхойлолт бөгөөд ижил төстэй бусад сортоос онцгой ялгарах шинж чанар, давуу талыг бүрэн ойлгомжтой гаргасан цогц мэдээллийг агуулсан байна.

14².2.2.хүсэлт гаргагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх тохиолдолд Иргэний хуульд заасан шаардлага итгэмжлэл;

14².2.3.давуу эрхийн магадалгаа;

14².2.4.хүсэлт гаргасан сортын ижил төстэй сортуудаас ялгаатайг нотлох шинж тэмдгийн зураг;

14².2.5.энэ хуулийн 29.1-д заасан үйлчилгээний хураамж төлсөн баримт;

14².2.6.холбогдох бусад материал.

14².3.Хүсэлт гаргагч нь хүсэлтдээ давуу эрхийн огноог нэхэмжилж болох бөгөөд энэ тохиолдолд давуу эрхийн огноо, эхний хүсэлтийн хуулбарыг хавсаргана.

14².4.Хүсэлт гаргагч хүсэлтийн талаар эцсийн шийдвэр гарах хүртэлх хугацаанд хүсэлтээ буцаан авч болно.

14².5.Сортын бүтээгчээс ирүүлсэн аливаа хүсэлтийг тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим хуудсандаа байршуулан нийтэд мэдээлнэ.

14².6.Хүсэлт гаргасан огноог хүсэлт илгээсэн огноо, цаг, минутаар тооцно.

14².7.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн сортын бүтээгчийн эрхийн хүсэлтэд шүүлт хийнэ.

14².8.Хүсэлт гаргагч мэдүүлсэн шинэ сортыг гадаад улс, олон улсын байгууллагад сортын бүтээгчийн эрх авахаар давхар мэдүүлсэн бол энэ тухайгаа тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

14².9.Шүүлт хийх явцад буюу эцсийн шийдвэр гарахаас өмнө хүсэлт гаргагч анхны ирүүлсэн сортын тодорхойлолтын агуулгын хүрээнд хүсэлтдээ нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

14².10.Хүсэлт гаргагчийн хүсэлтээр шүүлт хийх хугацааг хойшлуулж болох боловч хойшлуулсан хугацаа нь энэ хуулийн 14².11, 14².12-т заасан хугацаанаас хэтрэхгүй.

14².11.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийн эхний огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн сортын бүтээгчийн эрхийн хамгаалал олгох эсэх талаар шийдвэр гаргана. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг 3 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

14².12.Шинэ сортын бүтээгчийн эрхийн хамгаалал олгохоор шийдвэрлэсэн сортын нэр, тодорхойлолт, зургийг тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим хуудсандаа байршуулна.

14².13.Шинэ сорт болох нь нотлогдоогүй, сортын бүтээгчийн эрхээр хамгаалах боломжгүй бол шинэ сортын бүтээгчийн эрхийн хамгаалал олгохоос татгалзаж шийдвэрлэнэ.

14².14.Энэ хуулийн 14².13-т заасны дагуу татгалзсан тохиолдолд шүүлтийн дүгнэлтийн хуулбарыг уг дүгнэлт гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор хүсэлт гаргагчид цахимаар илгээнэ.”

3/12 дугаар зүйлийн 12.5, 12.6, 12.7, 12.8, 12.9, 12.10, 12.11, 12.12, 12.13, 12.14, 12.15, 12.16, 12.17, 12.18, 12.19, 12.20, 12.21, 12.22, 12.23, 12.24, 12.25, 12.26, 12.27, 12.28, 12.29, 12.30, 12.31 дэх хэсэг:

“12.5.Энэ хуулийн 12.3-т заасан бүртгэлд бүртгүүлэхийн өмнө сорт сорилт хийлгэсэн байх ба тухайн сортыг сорих хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана:

12.5.2.селекцийн талбаруудад хийгдсэн ажил, үр дүнгийн тайлан;

12.5.3.соригдох сортын ботаникийн тодорхойлолт, эх материалаас ялгагдах онцлог, тухайн сортын онцлог шинж тэмдэг;

12.5.4.сортын тоон шинж тэмдэг;

12.5.5.ирээдүйд хяналтын сорт болгох зорилгоор хүнс, хөдөө аж ахуйн таримал ургамлын генетик нөөцийн санд илгээх дээж;

12.5.6.фото зураг болон биет байдлаар дээж;

12.5.7.сортын бүтээгчийн танилцуулга.

12.6.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сортыг сорих хүсэлтийг хүлээн авч, энэ хуулийн 12.4-т заасан баримт бичгийн бүрдэл болон энэ хуулийн 12.3.2-т заасан шаардлагыг хангасан эсэхийг нягтална.

12.7.Энэ хуулийн 12.4-т заасан баримт бичгийн бүрдэл дутуу, эсхүл энэ хуулийн 12.3.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд баримт бичгийг нөхөн бүрдүүлэх, сортын нэрийг өөрчлөх боломжит хугацаа өгөх ба энэ хугацаанд дутуу баримтыг ирүүлээгүй, хуульд заасан шаардлагыг хангаагүй бол хүсэлт гаргаагүйд тооцно.

12.8.Энэ хуулийн 12.6-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг хүлээн авсан тухай тэмдэглэл үйлдэн, сорт сорилт хийлгэхээр энэ хуулийн 12.12-т заасан байгууллага, хуулийн этгээдэд үрийн дээжийг хүргүүлнэ.

12.9.Энэ хуулийн 12.8-д заасан тэмдэглэлд таримал болон сортын онцлогийг харгалзан уг сортыг сорих сорт сорилтын салбарын байршил, тоо, сорт сорилтод ашиглах үрийн хэмжээ, чанар, үрийг хүргүүлэх хугацааны талаар тусгана.

12.10.Үр, сортын зөвлөл сорих сортыг таримлын зүйл тус бүрээр боловсрох хугацаагаар нь бүлэглэж, хяналтын сортуудыг тодорхойлон, сорилтын багц батална.

12.11.Солбицон, эсхүл өөрөө өөртөө тоос хүртдэг таримлын сорт сорилтод цөм үр, эсхүл торгон үр, эрлийз сортын сорт сорилтод эрлийз үр ашиглана. Тусгайлан зааснаас бусад тохиолдолд үрийг ариутгаагүй байна.

12.12.Сорт сорилтыг Сорт сорилтын төв, эсхүл тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас сорт сорилт гүйцэтгэх эрх олгосон хуулийн этгээд гүйцэтгэнэ.

12.13.Сорт сорилтыг энэ хуулийн 12.10-т заасан сорилтын багцаар, энэ хуулийн 28.11.1-д заасан арга зүйгээр гүйцэтгэнэ.

12.14.Сортыг сориход шаардагдах зардлыг хүсэлт гаргагч хариуцна.

12.15.Сортыг сорих туршилтын талбай нь хөрс, цаг уурын нөхцөлийн хувьд тухайн бүс нутгийг төлөөлөхуйц байна.

12.16.Үр, сортын зөвлөлөөс сорт сорилтын явцад хяналт тавьж, үнэлгээ өгөх үүрэг бүхий хянан магадалгааны багийг тухайн таримлын талаар мэргэшсэн 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр томилно.

12.17.Хүсэлт гаргагч сорт сорилтын явцад хяналт тавьж болно.

12.18.Энэ хуулийн 12.12-т заасан байгууллага, хуулийн этгээдэд нь сорилтын үр дүнгийн тайланг жил бүрийн 12 дугаар сард Үр, сортын зөвлөлд хүргүүлнэ.

12.19.Энэ хуулийн 12.18-д заасан сорт сорилтын тайланд дор дурьдсан судалгааны үр дүнг тусгасан байна:

12.19.1.тухайн жилийн ургамал ургалтын хугацааны (олон наст ургамлын хувьд бүтэн жилийн) цаг агаарын нөхцөл, түүнд хийсэн агрономийн үнэлгээ, дүгнэлт;

12.19.2.соригдож байгаа сортын өсөлт, хөгжилтийн үе шатуудыг харуулсан ажиглалтын хуудас;

12.19.3.ургацын бүтцийн элементүүдийг задлан шинжилсэн материал;

12.19.4.ургацад хийсэн дисперсийн шинжилгээний дүн;

12.19.5.биохими, технологийн тодорхой голлох үзүүлэлтээр хийсэн лабораторийн шинжилгээний дүн;

12.19.6.тэсвэрийн үнэлгээний үр дүн.

12.20.Сорт сорилтын дүнгээр сортын аж ахуй болон биологийн үнэ цэнийг дараах үзүүлэлтээр хяналтын сорттой харьцуулж үнэлнэ:

12.20.1.өсөлтийн үе шат, үргэлжлэх хугацаа;

12.20.2.ургац хураах огноо;

12.20.3.ургац хураах үеийн га-гаас кг-д хөрвүүлсэн ургац, чийгийн хэмжээ;

12.20.4.ургацын чанар;

12.20.5.хамгийн бага мэдэгдэхүйц зөрүүтэй ургацын статистик шинжилгээ;

12.20.6.энэ хуулийн 12.5.3-т заасан онцлог шинж тэмдэг илэрсэн бол түүнд хийсэн дүн шинжилгээ.

12.21.Үр, сортын зөвлөл сорт сорилтын тайлан, сортын 3-аас доошгүй жилийн сорилтын үр дүнг харгалзан сортын үндэсний бүртгэлд ирээдүйтэй, эсхүл арилжааны сортоор бүртгэх эсэх талаар зөвлөмж гаргаж, тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

12.22.Сортын бүтээгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл сорт өмчлөгч тухайн сортыг ирээдүйтэй сортоор батлагдсанаас хойш 2-оос доошгүй

жил давуу чанараа хадгалж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн тохиолдолд нутагшсан сортоор бүртгүүлэх хүсэлтийг тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

12.23.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 12.22-т заасан хүсэлтийг хянаж, тухайн сортыг нутагшсан сортоор бүртгэх эсэх болон аль бүсэд нутагшуулах талаар Үр, сортын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг үндэслэн шийдвэрлэнэ.

12.24.Сортын үндэсний бүртгэлд ирээдүйтэй болон арилжааны сортоор бүртгүүлэх хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:

12.24.1.сорт бүтээгчийн хүсэлт болон сорт соригчийн хүсэлт;

12.24.2.сорт сорилтын үр дүнгийн 2-3 жилээс доошгүй хугацааны нэгтгэл, уг сортын баталгаат давуу байдлыг баталсан статистикийн шинжилгээний дүн;

12.24.3.холбогдох биохимийн үзүүлэлтүүдийг шинжилсэн лабораторийн шинжилгээний дүн;

12.24.4.биотик ба абиотик хүчин зүйлсийн тэсвэрийн үнэлгээний үр дүн;

12.23.5.Үр, сортын зөвлөлөөс томилогдсон хянан магадлагааны багийн үйлдсэн акт, дүгнэлт;

12.24.6.энэ хуулийн 12.21, 12.23-т заасан Үр, сортын зөвлөлийн зөвлөмж;

12.24.7.тухайн сортын цөм үрийн хэмжээ, чанар, түүнийг баталсан мэргэжлийн байгууллага, этгээдийн дүгнэлт.

12.25.Нутагшсан сортоор бүртгүүлэх хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:

12.25.1.тухайн сортын улсын болон бүсийн хэмжээнд тариалагдаж буй талбайн хэмжээ, түүнийг баталгаажуулсан аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын албан бичиг;

12.25.2.энэ хуулийн 12.23-т заасан Үр, сортын зөвлөлийн зөвлөмж.

12.26.Нутгийн уугуул сортыг энэ хуулийн 12.16-д заасан хянан магадалгааны багийн дүгнэлтийг үндэслэн сортын үндэсний бүртгэлд бүртгэнэ.

12.27.Сорт бүтээгчийн эрхээр хамгаалагдсан сортыг хамгаалагдсан сортын ангилалд бүртгэнэ.

12.28.Сортын үндэсний бүртгэлд бүртгэгдсэн сортыг Үр сортын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн өөр ангилалд шилжүүлж болно.

12.29.Сортын үндэсний бүртгэлд сортын дараах мэдээллийг бүртгэнэ:

12.29.1.таримлын төрөл, зүйл ба сортын нэр;

12.29.2.сортын гарал үүсэл, сорт бий болгосон селекцийн арга;

12.29.3.хувиргасан амьд организмын гаралтай сортуудад энэ талаарх мэдээлэл;

12.29.4.сортын биологи, аж ахуйн үнэ цэнийг тогтоосон сорилтын дүн;

12.29.5.сортын ялгаатай, жигдэрсэн, тогтвортой байдлыг тогтоосон туршилтын үр дүн;

12.29.6.сортын бүтээгчийн, эсхүл сортын бүтээгчээр нэмж бүртгүүлэх этгээдийн, эсхүл төлөөлөх этгээдийн нэр, хаяг;

12.29.7.сортыг сортын үндэсний бүртгэлд бүртгэсэн огноо;

12.29.8.сортыг үндэсний бүртгэлээс хассан огноо, шалтгаан.

12.30.Мэргэжлийн эрдэм шинжилгээний болон хяналтын байгууллага сортын үндэсний бүртгэлд бүртгэгдсэн сортод хяналт тавих зорилгоор үр үржүүлэгчдээс, эсхүл үрийн худалдаанаас дээж авч болно.

12.31.Дараах тохиолдолд сортыг сортын үндэсний бүртгэлээс хасна:

12.31.1.энэ хуулийн 12.28-д заасан тохиолдол үүссэн;

12.31.2.бүртгэгдсэн сортын бүтээгч сортыг бүртгэлээс хасуулах тухай хүсэлтээ тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн;

12.31.3.энэ хуулийн 25.1.1-т заасны дагуу сортыг хамгаалагдсан сортоор бүртгэх үед сорт ялгаатай биш, эсхүл жигдэрсэн биш, эсхүл тогтворжсон биш байсан нь нөхөн тогтоогдсон,

12.31.4.сортын бүтээгч энэ хуулийн 29.1-д заасан тэмдэгтийн хураамжийг төлөөгүй.”

4/13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 13.6, 13.7, 13.8, 13.9, 13.10, 13.11, 13.12, 13.13 дахь хэсэг:

13.4.Дараах шаардлагыг хангасан тохиолдолд сортын бүтээгчийн эрх олгоно:

13.4.1.шинэ сортын бүтээгчийн эрх авах тухай хүсэлтээ энэ хуулийн 14.1-д заасны дагуу тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргасан байх;

13.4.2.энэ хуулийн 14² дугаар зүйлд заасан журмын дагуу тухайн сортыг шинэ болохыг тогтоосон байх;

13.4.3.энэ хуулийн 14¹ дүгээр зүйлд заасны дагуу шинэ сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоосон албан ёсны байгууллагын тайланг хавсаргасан байх;

13.4.4.шинэ сортын нэр нь энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагад нийцэж, хадгалагдсан байх;

13.4.5.Энэ хуулийн 29.1-д заасан сортын бүтээгчийн эрх олгоход төлөх тэмдэгтийн хураамжийг төлсөн байх.

13.5.Энэ хуулийн 13.4-т заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтыг цахимаар хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сортын бүтээгчийн эрх олгож, энэ тухай сортын бүтээгчид мэдэгдэнэ.

13.6.Шинэ сортыг хэд хэдэн этгээд хамтарч бүтээсэн бол хамтран ажиллах гэрээг үндэслэн сортын бүтээгчийн эрхийг олгоно.

13.7.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сортын бүтээгчийн эрх олгосон даруй цахим хуудастаа байршуулан нийтэд мэдээлнэ.

13.8.Энэ хуулийн 14.12-д заасны дагуу шинэ сортын ялгаатай, жигдэрсэн, тогтворжсон болохыг тогтоосон тайланг харилцан хүлээн зөвшөөрөх талаар хамтран ажиллах гэрээтэй орны эрх бүхий байгууллагад хамгаалагдсан шинэ сортыг бүртгэснээс хойш ажлын 3 хоногт багтаан мэдээлнэ.

13.9.Хүсэлт ирүүлсэн сорт нь энэ хуулийн 13.4-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд сортын бүтээгчийн эрх олгохоос татгалзаж, сортын бүтээгчид мэдэгдэнэ.

13.10.Энэ хуулийн 13.9-д заасны дагуу сортын бүтээгчийн эрхийг олгохоос татгалзсан тохиолдолд сортын бүтээгч гомдлоо тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болно.

13.11.Сортын бүтээгч нь энэ хуулийн 13.4-т заасан нотлох бичиг баримтыг дутуу ирүүлсэн тохиолдолд энэ талаар мэдэгдсэнээс хойш ажлын 5 өдөрт багтаан нөхөн ирүүлж болно. Энэ хугацаанд бичиг баримтыг бүрэн ирүүлээгүй бол хүсэлт гаргаагүйд тооцно.

13.12.Энэ хуулийн 13.11-т заасны дагуу хүсэлт гаргаагүйд тооцсон тохиолдолд сортын бүтээгч дахин хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд энэ хуулийн 29.1-д заасан сортын бүтээгчийн эрх олгоход хураах тэмдэгтийн хураамжийг дахин төлнө.

13.13.Энэ хуулийн 29.1-д заасан сортын бүтээгчийн эрхийг хүчинтэй байлгах үйлчилгээнд төлөх тэмдэгтийн хураамжийг сортын бүтээгч жил бүр төлнө.

5/6 дугаар зүйлийн 6.2.5 дахь заалт:

“6.2.5.усалгаатай тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байсан туршлагатай байх.”

2 дугаар зүйл.Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “тодорхой хязгаарын хүрээнд сортын бүтээгчийн эрх үйлчлэхгүй байж болно.” гэснийг “сортын бүтээгчийн эрх үйлчлэхгүй.” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.3, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.8, 14.11, 20 дугаар зүйлийн 20.3, 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

**ҮРИЙН ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үрийн тариалангийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “болон ариутгал, халдваргүйтгэлийн” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 29.5, 29.6, 29.7, 29.8, 29.9, 29.10, 29.11, 29.12, 29.13, 29.14, 29.15, 29.16, 29.17 дахь хэсэг нэмсүгэй:

29 дүгээр зүйлийн 29.5, 29.6, 29.7, 29.8, 29.9, 29.10, 29.11, 29.12, 29.13, 29.14, 29.15, 29.16, 29.17 дахь хэсэг:

“29.5.Төр, хувийн хэвшлийн лабораторийн шинжилгээний дүнтэй холбоотой маргааныг хянах, баталгаажуулах, эцсийн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий үндэсний лавлагаа лаборатори ажиллана.

29.6.Үндэсний лавлагаа лаборатори нь дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

29.6.1.үйл ажиллагааныхаа чиглэлээр үндэсний хэмжээнд, эсхүл олон улсын түвшинд итгэмжлэгдсэн байх;

29.6.2.чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байх;

29.6.3.оношлуур, эм урвалж, цомог үйлдвэрлэдэг бол мал эмнэлгийн мэргэшсэн бусад байгууллагаар баталгаажуулдаг байх;

29.6.4.бүс нутгийн болон олон улсын холбогдох лабораторитай арга зүй, хамтын ажиллагааны харилцаатай байх;

29.6.5.олон улсын сорилд жил бүр хамрагдаж, үр дүнг баталгаажуулсан байх, улсын төсвийн зардлаар гүйцэтгэх;

29.6.6.мэргэшсэн, дадлага, туршлагатай шинжээчдийн багтай байх;

29.6.7.лабораторийн зохистой дадал (Good Laboratory Practice) нэвтрүүлсэн, биоаюулгүй байдал, биохамгааллын шаардлага хангасан байх.

29.7.Үндэсний лавлагаа лабораторийн эрх авах лаборатори нь энэ хуулийн 29.6-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан болохыг нотлох баримтыг бүрдүүлэн, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлтийн хамт ирүүлнэ.

29.8.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь үндэсний лавлагаа лабораторийг баталгаажуулах, эрхийг нь түр түдгэлзүүлэх, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

29.9.Мал, амьтны өвчний оношилгоо, тандалт, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, үлдэгдлийн шинжилгээ хийх эрх бүхий өмчийн бүх хэлбэрийн мал эмнэлгийн лаборатори нь сүлжээ байдлаар ажиллана.

29.10.Энэ хуулийн 29.9-д заасан лаборатори нь бүх түвшинд биоаюулгүй ажиллагаа, биохамгааллын зааврыг мөрдөж ажиллана.

29.11.Сүлжээ лаборатори нь энэ хуулийн 29.1-д заасан лабораторийн баталгаажуулсан оношлуур, эм урвалж, цомог, шинжилгээний стандарт, стандарт ажиллагааны заавруудыг ашиглан шинжилгээ, сорил, баталгаажуулалт хийнэ.

29.12.Сорьц авах, хүргэх үйл ажиллагааг холбогдох журам, стандарт, стандарт ажиллагааны зааврын дагуу хэрэгжүүлнэ.

29.13.Сүлжээ лаборатори нь дээд шатны лабораторид улирал тутам харьцуулалтын сорьц илгээн шинжлүүлэх ба анхан шатны лабораторийн шинжилгээгээр сэжигтэй болон эерэг үр дүн үзүүлсэн сорьцыг тухай бүр дээд шатны лабораторид хүргүүлэн баталгаажуулна.

29.14.Баталгаажуулах шинжилгээг доод шатны лабораторийн шинжилсэн аргаар болон олон улсын байгууллагын зөвлөмжилсөн мэдрэг, өвөрмөц чанар өндөртэй аргаар тус тус гүйцэтгэнэ.

29.15.Сүлжээ лаборатори нь оношилгоо, тандалт, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, үлдэгдлийн шинжилгээ, сорил, баталгаажуулалтын ажлын тайланг цахимаар жил бүр харьяалах дээд шатны лабораторид хүргүүлнэ.

29.16.Сүлжээ лаборатори дахь төрийн өмчийн лабораторийн үйл ажиллагааны зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх ба батлагдсан тарифын дагуу төлбөр авч, улсын төсөвт төвлөрүүлнэ.

29.17.Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийх төлбөрийг хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж хариуцна.”

2 дугаар зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “бүрдүүлэх” гэсний дараа “, мэдээлэх” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг:

“Монгол Улсын нутаг дэвсгэрт оношлогдсон мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалтыг доор дурдсан ангиллаар мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална:”

2/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:

“12.3.Мал, амьтны өвчин, халдваргүй тайван байдлыг улс, бүс, нутаг, хамгаалалттай аж ахуйгаар тогтоон мэдээлэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3/27 дугаар зүйлийн 27.14 дэх хэсэг:

“27.14.Мал эмнэлгийн болон лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээний загвар, хэрэглэх зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.”

4/28 дугаар зүйлийн 28.13 дахь хэсэг:

“28.13.Малын эмийн салбар зөвлөл болон фармакопейн хорооны ажиллах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.”

5/30 дугаар зүйлийн 30.20 дахь хэсэг:

“30.20.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төр, хувийн хэвшилд ажиллаж буй малын эмчийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалтыг зохион байгуулах, малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох асуудлыг хариуцна. Төгсөлтийн дараах үргэлжилсэн сургалт явуулах, малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг, итгэмжлэл олгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

4 дүгээр зүйл зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийн “журам болон мах бэлтгэл, отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэлийг” гэснийг “журмыг” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт”, 17.2 дахь хэсгийн “Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалтад багтсан” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийн “Засгийн газраас тогтоосон орон тооны хязгаарт багтаан” гэснийг, 30 дугаар зүйлийн 30.23 дахь хэсгийн “мал эмнэлгийн арга хэмжээний норматив тогтоох,” гэснийг, мөн заалтын “, малын эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “улсын төсөвт байгууллагатай шууд гэрээ байгуулах хэлбэрээр эм, худалдан авах үнэ” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.10, 15 дугаар зүйлийн 15.11, 18 дугаар зүйлийн 18.2, 27 дугаар зүйлийн 27.6, 25 дугаар зүйлийн 25.2, 29 дүгээр зүйлийн 29.4, 30 дугаар зүйлийн 30.18 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 9.14 дэх хэсэг нэмсүгэй:

“9.14.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь малын генетик нөөцийг ашигласан үйл ажиллагааны тайланг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын эхний хагаст багтаан ирүүлнэ.”

2 дугаар зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсгийн “үнэлүүлж,” гэсний дараа “үржүүлэх тохиромжтой бүс нутгийг тогтоолгож,” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “импортлох” гэсний дараа “үржлийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг:

“8.7.Энэ хуулийн 4.1.11-д заасан этгээдийг малчин болохыг баталгаажуулж, энэ хуулийн 5.7-д заасан нэгдсэн сангаас цахим тодорхойлолт олгоно.”

2/9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг:

“9.4.Гадаадаас сайжруулагч мал авах тусгай зөвшөөрөлд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3-т зааснаас гадна тухайн малыг өсгөн үржүүлэх бүс нутгийг заана.”

3/11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг:

“11.3.Дараах шаардлага хангасан мал зүйчид шинжээч, тэргүүлэх, зөвлөх мэргэшлийн зэргийг олгож бүртгэх ба энэ чиг үүргээ гэрээний үндсэн дээр мэргэжлийн төрийн бус байгууллагад шилжүүлж болно:

11.3.1.Салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын баталсан хөтөлбөрийн дагуу 14-өөс доошгүй хоногийн төрөлжсөн сургалтанд хамрагдаж зохих үнэлгээ, дүгнэлт авсан мал зүйчид мэргэшлийн шинжээч зэрэг олгох бөгөөд ингэснээр мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ эрхлэх эрх үүснэ.

11.3.2.Малын генетик нөөцийг ашиглах, хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, эрдэм шинжилгээний

байгууллагаар баталгаажуулсан, мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан шинжээч мэргэшлийн зэрэг бүхий мал зүйчид тэргүүлэх зэрэг олгоно.

11.3.3.Малын генетик нөөцийг ашиглах, хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх чиглэлээр шинэ бүтээл, ашигтай загварын гэрчилгээ авсан, мэргэжлээрээ 15 ба түүнээс дээш жил ажилласан тэргүүлэх мэргэшлийн зэрэг бүхий мал зүйчид зөвлөх зэрэг олгоно.”

4/13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг:

“13.2.Монгол Улсад баталгаажсан үүлдэр, омгийн малыг нутагшсан болон уугуул орчинд нь, гадаад улсаас импортлон үржүүлж буй өндөр ашиг шимт малыг гадаадаас сайжруулагч мал авах тусгай зөвшөөрөлд заасан бүс нутагт байршуулан үржүүлнэ.”

5/11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг:

“11.4.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд мэргэшлийн зэрэг олгохгүй.”

4 дүгээр зүйл.Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийн “гүйцэтгэнэ.” гэснийг “гүйцэтгэж, энэ хуулийн 5.7-д заасан нэгдсэн санд мэдээллийг оруулна.” гэж, мөн зүйлийн 5.7 дахь хэсгийн “Малын генетик нөөцийн мэдээллийг” гэснийг “Энэ хуулийн 5.1-д заасан малын генетик нөөцийн бүртгэлийн мэдээллийг” гэж, мөн хэсгийн “байгууллагын бүтцийн нэгж” гэснийг “байгууллага” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “арга зүй, аргачлал, зааврын” гэснийг “арга зүйн” гэж, мөн зүйлийн 6.9 дэх хэсгийн “журам, энэ хуулийн 6.2-т заасан зааврыг” гэснийг “журмыг” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл, зэрэг дэв” гэснийг “Мэргэшлийн зэрэг” гэж, мөн зүйлийн 11.8 дахь хэсгийн “жишиг үнийн хэмжээ, үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний төрөл бүрээр мөрдөх технологийн журам, зааврыг” гэснийг “хэмжээг” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн “хамгаалж, үржүүлэх арга хэмжээ авч, удам гарвал нь тодорхой, стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгч бойжуулж зах зээлд борлуулсан малчин, мал бүхий этгээд, энэ хуулийн 11.2-т заасан үйлчилгээний нэгжид Засгийн газраас дэмжлэг, урамшуулал олгож болох бөгөөд урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.” гэснийг “хамгаалах арга хэмжээг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсгийн “статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.8 дахь хэсгийн “иргэн” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.9, 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалт, 8.8, 8.9 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.8, 11 дүгээр зүйлийн 11.5, 11.10 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.10.2, 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

**МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн “ажиллуулж болох бөгөөд бүлгийн үлгэрчилсэн дүрмийг хүнс, хөдөө аж ахуйн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг “ажиллуулна.” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт, 5.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.2, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг, 13 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/11¹ дүгээр зүйл:

“11¹ дүгээр зүйл. Зээлийн хүүгийн татаас олгох журам

11^{1.1}. Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараа оны зээлийн хүүгийн татааст олгох зардлын тооцооллыг жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны дотор Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

11^{1.2}. Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага санд улсын төсвөөс нэмэлт санхүүжилт батлагдсан тохиолдолд тухайн жилийн 1 дүгээр улиралд багтаан турш татаасын дэмжлэгт хамрагдах хүсэлтийг олон нийтэд нээлттэй зарлаж, цахимаар хүлээж авна.

11^{1.3}. Зээлийн хүүгийн татаасын дэмжлэгт хамрагдахыг хүссэн хуулийн этгээд дараах бичиг баримтыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар хүргүүлнэ.

11^{1.3.1}. зээлийн хүүгийн татаасын дэмжлэгт хамрагдах тухай хүсэлт гаргасан албан бичиг;

11^{1.3.2}. гүйцэтгэх захирлын иргэний үнэмлэхийн хуулбар;

11^{1.3.3}. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон шаардлагатай бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

11^{1.3.4}. экспортод гаргадаг бүтээгдэхүүний танилцуулга,

11^{1.3.5}. арилжааны банкны бизнесийн зээлийн гэрээний хуулбар болон барьцааны гэрээний хуулбар;

11^{1.3.6}. сүүлийн нэг жилийн зээлийн хүүд төлсөн төлбөрийг баталгаажуулсан харилцагч арилжааны банкны тодорхойлолт;

11^{1.3.7}. аудитаар баталгаажсан сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан;

11^{1.3.8}. сүүлийн нэг жилд экспортод гаргасан бүтээгдэхүүний MN тодотголтой гаалийн мэдүүлгийн хуулбар;

11¹.3.9.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээр бүртгүүлсэн тодорхойлолт.

11¹.4.Татаасын дэмжлэгийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно.

11¹.5.Энэ хуулийн 11¹.4-т заасан сонгон шалгаруулалтыг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний байгуулсан ажлыг хэсэг зохион байгуулна.

11¹.6.Энэ хуулийн 11¹.5-д заасан ажлын хэсэг татаас олгох сонгон шалгаруулалтын зар гаргах, хүлээн авах, хариу илгээх, үр дүнг мэдээллэх ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулна.

11¹.7.Өмнөх онд дотоодын банкнаас авсан арилжааны зээлийн хүүд татаас олгоно.

11¹.8.Сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн шаардлага хангасан аж ахуйн нэгжид жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр тухайн жилд олгох татаасын хувь, хэмжээг тогтооно.

11¹.9.Сан нь жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр сонгон шалгаруулалт зохион байгуулсан жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны дотор зээлийн хүүгийн татаасыг олгоно.

2/9 дүгээр зүйлийн 9.6, 9.7, 9.8 дахь хэсэг:

“9.6.Кластерын байгууллага нь өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор мэдлэг, мэдээллийн дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйлчилгээ үзүүлэхдээ бүтээмжийн болон инновацийн үйл ажиллагааг идэвхжүүлэхээс гадна кластер хоорондын стратегийн түншлэлийг хөгжүүлэх үүрэг гүйцэтгэнэ.

9.7.Эрдэм шинжилгээ, судалгааны, боловсрол, санхүүгийн байгууллага, салбарын мэргэжлийн холбоо болон төрийн захиргааны байгууллага нь эрхлэх асуудлын хүрээнд кластерын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж болно.

9.8.Кластерын гишүүн нь дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

9.8.1.кластерын алсын хараа, эрхэм зорилго, стратеги, брэнд, инновацийн төсөл хэрэгжүүлэхэд тодорхой чиг үүрэгтэй оролцох;

9.8.2.бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийн сүлжээний дагуу хамтран ажиллаж буй гурав ба түүнээс дээш нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд байх;

9.8.3.кластерын оролцогч талуудын харилцаа, хамтын ажиллагаа, эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулсан хамтын ажиллагааны гэрээтэй байх.”

2 дугаар зүйл.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “шалгаруулах журмыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.7-д заасны дагуу” гэснийг “шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг” гэж, 17 дугаар

зүйлийн 17.1.13 дахь заалтын “хаагчийг” гэснийг “хаагч, бизнес инкубацийн үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн өмчит хуулийн этгээдийг” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3, 9.4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.3, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

.2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хоршооны тухай хуульд доор дурдсан агуулгатай "12¹ дугаар зүйл нэмсүгэй:

"12¹ дугаар зүйл.Улсын шилдэг хоршоо шалгаруулах, шагнах

12¹.1.Хоршоог хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж буй 5 хүртэлх хоршоог жил бүр Улсын шилдэг хоршоогоор шалгаруулж, шагнах бөгөөд хоршоог "Улсын шилдэг хоршоо"-оор зөвхөн нэг удаа шалгаруулж, шагнана.

12¹.2.Улсын шилдэг хоршоог шалгаруулах, шагнахад шаардагдах хөрөнгийг хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

12¹.3.Улсын шилдэг хоршоог сонгон шалгаруулах ажлын хэсгийг хоршооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулна.

12¹.4.Улсын шилдэг хоршоонд нэр дэвшигчийн материалыг орон нутгийн хоршооны асуудал хариуцсан байгууллага хүлээн авч ерөнхий шаардлага хангасан материалыг хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийн “жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг” гэснийг “жагсаалтыг” гэж, мөн зүйлийн 4.10 дахь хэсгийн “4.5, 5.1.7-д” гэснийг “4.5-д” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар хот

**ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 11.2.7, 11.2.8 дахь заалт нэмсүгэй:

“11.2.7.паркийн нутаг дэвсгэрт хэрэгжих төсөл, арга хэмжээ, түүний дэд бүтэц, бүтээн байгуулалтад шаардлагатай усан хангамж, дулаан хангамж, эрчим хүчний эх үүсвэрийн төлөвлөлт, нэгжүүдийг хангах зураглал;

11.2.8.авто зам, төмөр зам, усан хангамж, дулаан хангамж, цахилгаан хангамж зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөлт, зураглал.”

2 дугаар зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалтын “паркийн” гэсний өмнө “энэ хуулийн 8.1.7-д заасан зөвлөлөөр дүгнэлт гаргуулсан” гэж, мөн зүйлийн 11.2.2 дахь заалтын “паркийн” гэсний өмнө “энэ хуулийн 8.1.7-д заасан зөвлөлөөр дүгнэлт гаргуулсан, улсын хөгжлийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан” гэж, мөн зүйлийн 11.2.3 дахь заалтын “паркийн” гэсний өмнө “Технологи дамжуулах тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас технологийн түвшний үнэлгээ хийх эрх авсан байгууллагаар хийлгэсэн” гэж, мөн зүйлийн 11.2.4 дэх заалтын “байгаль” гэсний өмнө “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.3, 8.2-т заасан эрх бүхий байгууллагаар хийлгэсэн” гэж, мөн зүйлийн 11.2.5 дахь заалтын “жагсаалт” гэсний дараа “, нэгжүүдийн кластерын зарчмаар хоршин ажиллах ерөнхий бүдүүвч” гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “дэмжлэгийг” гэсний дараа “төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн” тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Паркийн үйл ажиллагаанд” гэснийг “Энэ хуулийн 11.4, 13.3.1, 13.3.2-т заасан холбогдох гэрээг байгуулсан хуулийн этгээдэд” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын “холбогдох журмыг батлах” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.